

**ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН АЛБАНЫ
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ
ТАЙЛАН**

ДХЭУА нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар Эрсдэлийн удирдлага болон хяналтын ажлын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Эрсдэлийн удирдлагын чиглэлээр:

ДХЭУА нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар Эрсдэлийн удирдлагын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 2026 оны бизнес төлөвлөгөөний эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний 1-р улирлын биелэлтийг хугацаанд нь гарган хүргүүлсэн.
- “Багануур” ХК-ийн 2026 оны бизнес төлөвлөгөөний тодотголын эрсдэл тодорхойлсон:

Тодотголд орсон ажлуудын эрсдэлийг холбогдох нэгжийн эрсдэл хариуцагч нараар тодорхойлуулан, батлагдсан маягтын дагуу гаргуулан авч нэгтгэхэд төлөвлөгдсөн ажлаас 10 эрсдэл бүртгэгдэж, үнэлэгдсэн ба эрсдэлийн түвшингээр нь эрэмбэлэхэд **өндөр эрсдэлтэй 8, дунд эрсдэлтэй 2** ажил байна. Тодорхойлсон эрсдэл, түүнд хийсэн үнэлгээ, хариу арга хэмжээний төлөвлөгөөнөөс харахад дийлэнх эрсдэл нь компанийн хяналтаас гадуур гадаад хүчин зүйлээс шалтгаалсан эрсдэл байх боловч өөрсдийн нөөц бололцооны хүрээнд удирдаж болох эрсдэлүүдэд дүн шинжилгээ хийх, үнэлэх, төлөвлөх, гадаад хүчин зүйлийн нөлөөтэй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг нь бууруулж ажилласнаар компани үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэл **дунд** түвшинд байхаар байна.

Хяналтын ажлын чиглэлээр:

2026 оны эхний хагас жилд байнгын 2, төлөвлөгөөт 12 нийт 14 хяналт хийхээр төлөвлөснөөс байнгын 2, төлөвлөгөөт 12, төлөвлөгөөт бус 2 нийт 16 хяналтыг хийж 114 хувийн гүйцэтгэлтэй байна.

Д/д	Хяналтын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Байнгын хяналт	2	2	100%
2	Төлөвлөгөөт хяналт	12	12	100%
3	Төлөвлөгөөт бус		2	100%
Нийт		14	16	114%

2026 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт:

№	Төлөвлөгөөт хяналт	Чиглэл
1	ТМА-ын ашиглалт, тэсэлгээний ажил явуулах үйл ажиллагаанд	Технологийн
2	Ил уурхайн үйл ажиллагаанд	
3	Багануур сувилал ХХК-ийн 2025 оны үйл ажиллагаанд	Санхүү, хуулийн

4	УШХ-ийн т/т-ийн тасралтгүй ажиллагааг хангах, эвдрэлийг цаг тухайд илрүүлэх урьдчилан сэргийлэх ажлыг хянах	Техникийн
5	Цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс олголтын байдалд эргэн хяналт	Санхүү
6	Аюулгүй байдлын дүрэм хууль эрх зүйн баримтад нийцлийн хяналт	Технологийн
7	ХНТХ-ийн технологийн машины тасралтгүй үйл ажиллагааг хангах тогтолцоонд	Техникийн
8	Сэлбэг материалын зарцуулалт, болон үлдэгдэлд	Санхүү
9	Засварын хэсгийн тоног төхөөрмжийн тасралтгүй ажиллагааны байдалд	Техникийн
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд	Технологийн
11	ҮАГ-аас өгсөн зөвлөмжийн албан шаардлага хангуулах биелэлтэд явцын хяналт	Санхүү
12	Ажлын байрны тодорхойлолт шинэчлэх хийх ажлын явцад хяналт	Хууль
Байнгын хяналт		
13	Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд	Хууль,санхүү
14	Гаднаас ирсэн хяналт шалгалтын бүртгэл, гүйцэтгэлийг хангуулах тайлан мэдээг гаргах, тайлагнах, хүргүүлэх	
Төлөвлөгөөт бус		
1	ХАБЭА-н хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу даралтаар буусан ажилчдын бүртгэлд	Технологи
2	Тэсрэх материалын үйл ажиллагаа зарцуулалтад	Хууль,технологи

Засгийн газрын үүрэг даалгавар, гаднын хяналтын чиглэлээр:

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн “Дотоод Хяналт, Эрсдэлийн Удирдлага”-ын газраас өгсөн “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж болон үүргийн биелэлтийг хангуулж, 2026 оны 1-р улирлын цахим мэдээ, үнэлгээний тайланг хугацаанд нь хүргүүлж 92%-тай үнэлэгдсэн бол 2-р улирлын тайланг 7 дугаар 25-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна.

Мөн Засгийн газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжилтийг нэгтгэн 2026 оны 05 дугаар сарын байдлаар толгой компанид хүргүүлсэн бөгөөд 2026 оны 2 дугаар улирлын хэрэгжилтийг 2026 оны 07 дугаар сарын 05-ны дотор хүргүүлнэ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДХЭУА-НЫ МЭРГЭЖИЛТЭН

Т.ЗОЛЗАЯА

ТАНИЛЦСАН:

ДХЭУА-НЫ ДАРГА

Б.ХАЖИДМАА